

ᠤᠨᠳᠡᠰᠨᠢᠢ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠬᠠᠰᠠᠷ
ᠭᠤᠢᠴᠡᠳᠲᠦᠭᠡᠯ-ᠨᠢᠢᠴᠯᠢᠢᠨ
ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠲᠥᠯᠥᠪᠪᠯᠦᠭᠡᠭᠡ
ᠲᠠᠲᠠᠨ ᠪᠤᠭᠤᠳᠰᠠᠨ ᠪᠠᠨᠭᠲᠠᠢ
ᠬᠣᠯᠪᠣᠣᠲᠤ
ᠰᠢᠶᠢᠳᠪᠡᠷᠦᠭᠦᠳᠢᠨ
ᠬᠡᠷᠦᠭᠵᠢᠯᠲ, ᠶᠢᠨ ᠨᠥᠯᠡᠭᠡ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ТАТАН БУУГДСАН БАНКТАЙ
ХОЛБООТОЙ
ШИЙДВЭРҮҮДИЙН
ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газар

2023 он

ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр:

Татан буугдсан банктай холбоотой шийдвэрүүдийн хэрэгжилт, үр нөлөө

2.Аудитын код:

ГНАГ-2023/20-ШТА/ГА

3.Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэнэ.

4.Аудитын зорилт:

Татан буугдсан банктай холбоотой шийдвэрүүдийн хэрэгжилт, үр нөлөө сэдвээр гүйцэтгэл-нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- *Банкийг татан буулгах шийдвэр нь зохих хууль тогтоомжид нийцэж байна уу?*
- *Банкийг татан буулгах шийдвэрийн хэрэгжилт үр нөлөөтэй байна уу?*

5.Аудитын хамрах хүрээ:

Аудитад Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, татан буугдсан банканд томилогдсон бүрэн эрхт төлөөлөгч болон эрх хүлээн авагч, иргэн, аж ахуйн нэгж, бусад холбогдох байгууллагын үйл ажиллагааг хамруулна.

Аудитад Банкны тухай хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар Банкны эрх хүлээн авагчийг томилж банкныг албадан татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа, эрх хүлээн авах арга хэмжээ дуусгавар болоогүй дараах банкнуудыг хамруулна. Үүнд:

№	Банкны нэр	Монгол банкнаас гаргасан банк татан буулгах шийдвэр
1	Зоос банк	Монгол банкны Ерөнхийлөгчийн 2009 оны 659 дүгээр тушаалаар банкныг албадан татан буулгасан
2	Хадгаламж банк	Монгол банкны Ерөнхийлөгчийн 2013 оны А-157 дугаар тушаалаар банкныг албадан татан буулгасан
3	Капитал банк	Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-96 дугаар тушаалаар банкныг албадан татан буулгасан

Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа арван жил байна" гэсэн заасан тул аудитад хөөн хэлэлцэх хугацаа дууссан, төрийн оролцоогүй, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг аваагүй банкны үйл ажиллагаа эрхэлж байсан хуулийн этгээдийг хамруулаагүй болно.

Аудитыг эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, мэдээ, тайлан, мэдээлэл болон бусад нотлох баримтад үндэслэн хийнэ.

6. Үндсэн мэдээлэл:

Банкны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт заасны дагуу банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай Монгол банкны шийдвэр гарснаар банкны эрх хүлээн авагчийг томилох, түүнд банк, банкны удирдлагын бүрэн эрх, банкны хөрөнгийг захиран зарцуулах эрх, хяналтыг шилжүүлэх, банкныг татан буулгах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Засгийн газрын 2002 оны “Банкны өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 109 дүгээр тогтоолоор татан буугдсан, дампуурсан банк болон банкны өр барагдуулах газраас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн зээлийн өрийг төлүүлэхээр шүүхэд гаргасан нэхэмжлэлийн дагуу гарсан шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх хуудсыг Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газарт шилжүүлж, тэдгээрийн дагуу барагдуулах зээлийн төлбөр тооцоо хийх, мэдээ судалгаа гаргах, барагдуулсан зээлийн өрийг улсын төсөвт төвлөрүүлэх журам тогтоож мөрдүүлэхийг Санхүү, эдийн засгийн яам (хуучин нэрээр), мөн Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага дээр алга болсон шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсыг нөхөн гаргуулах талаар арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн яам (хуучин нэрээр)-д тус тус даалгасан байна.

Банкийг дараах үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд албадан татан буулгаж, банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгодог байна. Үүнд:

- *Банканд авсан албадлагын арга хэмжээний хүрээнд банкны банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож цуцалсан;*
- *Банкны тухай хуульд заасан банкны системд нөлөө бүхий банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй гэж Монгол банкны шийдвэр гарсан.*

Монгол банкны банкны бүтцийн өөрчлөлт хариуцсан нэгжээс тухайн банкныг албадан татан буулгах тухай саналаа Монгол банкны Ерөнхийлөгчид танилцуулж, Монгол банкны Ерөнхийлөгч нь Банкны хяналт шалгалтын хороогоор хэлэлцүүлэхээр шийдвэрлэдэг байна.

Банкийг албадан татан буулгах үйл ажиллагааны хэрэгжилт нь Банкны тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан нөхцөлөөр баталгаажуулдаг бөгөөд манай улсын санхүүгийн салбарт 1991 оноос хойш нийт 20 банк татан буугдсан байна.

Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах шалтгаанаар хүчингүй болгож, татан буулгасан байна. Үүнд:

- *Санхүү төлбөрийн чадваргүй болсны улмаас Банкны тухай хуулийн дагуу албадлагын арга хэмжээний хүрээнд банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон;*
- *Санхүү төлбөрийн чадваргүй болсны улмаас Аж ахуйн нэгжийн хуулиар дампуурал зарласан;*
- *Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хуульд заасан хэмжээнд хүргээгүйн улмаас банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон;*
- *Зөрчил дутагдлыг арилгах талаар Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүйн улмаас зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.*

Татан буугдсан банк нь зээлийн бодлого боловсруулж мөрдөөгүй, Монгол банкнаас баталсан холбогдох заавар, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлээгүй байсан нь эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар тогтоогдсон байна.

7.Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн үе шатанд судалсан баримт материал, хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн аудитын ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

8.Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэл болон нийцлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэнэ.

9.Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Банкны тухай хууль;
- Төв банк /Монгол банк/-ны тухай хууль;
- Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Татан буугдсан банктай холбоотой УИХ болон Засгийн газрын тогтоолууд;
- Татан буугдсан банктай холбоотой Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаал, шийдвэрүүд;
- Банкныг татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;
- Банкныг албадан татан буулгах шийдвэр гарсан өдрөөр тасалбар болгосон аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;
- Татан буугдсан банкны санхүүгийн тайлан;
- Монгол банкнаас банкныг татан буулгах тухай шийдвэрийг олон нийтэд мэдээлсэн баримт бичиг;
- Татан буугдсан банкны эрх хүлээн авагчийн шийдвэр;
- Татан буугдсан банкны үйл ажиллагаатай холбоотой Монгол банкны дүрэм, журам;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг Захиргаа, хууль эрх зүйн газрын хууль эрх зүйн менежер Б.Эрдэнэбаатар, аудитын удирдлагын менежер Б.Болормаа нар хэрэгжүүлж, аудитор Ж.Мөнхбилгүүн, Б.Мөнхтуяа, шинжээч Б.Мөнхцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ.

Аудит хийх хугацаа:

Аудитын урьдчилсан судалгааны үе шатны ажлыг 2023 оны 07 дугаар сарын 18-ний өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2023 оны 08 дугаар сарын 18-ний өдрөөс тус тус эхлэн, аудитын төлөвлөгөөг 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн дотор батлуулж, талбарын үе шатны ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлүүлж, аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор баталгаажуулж, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.